



Юань, Минь Чингийн үеийн монгол, хятад уран зохиолын харьцуулсан судалгаа

Сод

Өвөр Монголын Их Сургууль, Монгол судлалын дээд сургууль
БНХАУ-ын Цагаачлалын Удирдах Газар

Холбоо барих зохиогч: taivansuren@yahoo.com

Хүлээн авсан: 2020.07.04

Хянагдсан: 2020.08.25

Зөвшөөрсөн: 2020.09.28

Хураангуй

Монгол, хятад уран зохиолын харьцаа холбооны тухай судалгаа нь гол төлөв Юань, Мин, Чин улсын үеийн монгол, хятад уран зохиолыг харьцуулан судалсан судалгаан дээр төвлөрдөг. Энэ чиглэлийн судалгаанд голлох байр суурийг эзэлдэг эрдэмтэд бол Юньфэн, Б.Төмөрбагана, Жалга Чюси, Цолмонцэцэг, Намжилцэвээн, Ц.Хишигтогтох, Рэнцэндорж, Т.Цэрэнсодном, Б.Ринчэн, Чэнь Ганлун, Жиньрун, Бай Үйрун, Уеэ зэрэг олон эрдэмтэн, судлаачдыг дурдаж болно.

Хубилай хаан Юань улсыг байгуулсны дараа бүх улсыг нэгтгэж, монгол үндэстний байр суурьд томоохон өөрчлөлт гарч, монголчуудын нүүдлийн мал аж ахуйн соёл нь Дундад орны тариалах соёлтой харилцах болсноор соёлын хоорондох харилцаа ба солилцоо идэвхжиж монгол, хятад соёлын харилцаа үүсэж, монгол, хятад уран зохиолын харьцаа холбооны үндэс тавигдсан байна. Үүний дараа Мин улсын үед Монгол-Мингийн хооронд урт хугацааны туршид үргэлжилсэн дайн самууны улмаас монгол соёл, уран зохиолын хөгжил бууралтын шатанд орсон нь монгол, хятад уран зохиолын харьцаа холбоонд ихээхэн тусгалаа олжээ. Харин Манж Чин улсын үед монгол, хятад уран зохиолын харьцаа холбоонд урьд үеэс эрс хөгжсөнөөр Монголын уран зохиолын хөгжилд ихээхэн нөлөө үзүүлжээ.

Энэхүү өгүүлэлдээ Юань, Мин, Чингийн үе дахь Монгол, Хятад уран зохиолыг харьцуулан судалсан судалгааны тоймыг товч өгүүлэхийн зэрэгцээ монгол, хятад уран зохиолын харьцаа холбооны тухай өөрийн санал, дүгнэлтийг дэвшүүлэхийг зорьсон юм.

Түлхүүр үг

Юань, Мин, Чингийн монгол, хятад утга зохиол, харьцаа холбоо, харьцуулалт

Удиртгал

Юань, Мин, Чингийн үеийн монгол, хятад уран зохиолын судалгааны тойм

Монгол, хятад уран зохиолын харьцуулсан судалгаа нь голдуу Юань улсын үеийн монгол, хятад уран зохиолын харьцуулсан судалгаа болон Чин улсын үеийн монгол, хятадын уран зохиолын харьцуулсан судалгаанд төвлөрч байдаг.

Юань улсын үеийн монгол, хятад уран зохиолын харьцуулсан судалгааны талаар нэлээд амжилт гаргасан хүн бол Юньфэн (云峰-yun feng) болно. Түүний “Монгол, хятад уран зохиолын харьцаа холбооны түүх” (Yunfeng, 1997), “Юань улсын үеийн монгол, хятад уран зохиолын харьцуулсан судлал” (Yunfeng, 2005), “Монгол, хятад соёлын харилцааны хажуугийн ажиглалт — Монгол үндэстний хятад хэлээр зохиол бүтээлээ туурвиж байсан түүх” (Yunfeng, 1992) зэрэг эрдэм шинжилгээний тусгай ном хэвлүүлснээс гадна, “Монгол үндэстэн хийгээд монгол соёлын Юань улсын ший жүжгийн хөгжил дэвшилтэд үзүүлсэн нөлөө” (Yunfeng, 2003.04), “Монголчууд хийгээд монгол соёлын Юань улсын сул дууллын агуулгад үзүүлсэн нөлөө” (Yunfeng, 2004.02), “Чингийн үеийн монгол үндэстэн хятад хэлээр зохиол бүтээлээ туурвиж жич бичгийн сургуульд нөлөөлсөн нь” (Yunfeng, 2004.04) зэрэг тусгай сэдэвт өгүүлэл нийтэлж, монгол, хятад уран зохиолын харьцуулсан судалгааны чиглэлээр аспирант докторантын судалгааны ажлыг удирдаж хамгаалуулсан байна.

Б.Төмөрбагана Юань, Мин улсын үеийн монгол зохиолчдын хятадаар туурвисан зохиол бүтээлийг судлан “Эртний монгол зохиолчдын хятад зохиол туурвилын судлал” (Tumurbagana B. , 2002) гэх эрдэм шинжилгээний тусгай ном хэвлүүлж, “Эртний монгол зохиолчдын хятадаар зохиол бүтээлээ бичих болсон нийгэм түүхийн шалтгаан” (Tumurbagana B. , 1999.06) зэрэг өгүүллүүдийг нийтлүүлжээ. Үүнээс гадна, Чюси (秋喜- qiu xi)-гийн “Юань улсын үеийн монгол яруу найрагчдын хятад шүлэг дахь домогт өгүүлэмж” (Чюси, 2002.01), Цолмонцэцэгийн “Юанийн үеийн шүлэг дуулал туурвих түүхэн орчин нөхцөлийг товч өгүүлэх нь” (Tsolmontsetseg, 2005.02) зэрэг өгүүллүүд нь Юань улсын үеийн монгол, хятад уран зохиолын харьцуулан судалсан байна.

Чин улсын үеийн монгол, хятад уран зохиолыг харьцуулан судалж дорвитой судалгаа шинжилгээ хийсэн хүн Жалга юм. Жалгын “<Нэгэн давхар асар>, <Улаанаа уйхлах тэнхим> хийгээд <Улаан асрын зүүд>” (Jalga, 1984), “Харьцуулсан утга зохиол: утга зохиолын зэрэгцсэн мөн чанарын харьцуулсан судлал—Чин улсын үеийн монгол, хятад утга зохиолыг харьцуулсан тухай өгүүлэмж” (Jalga, 2002) зэрэг Чингийн үеийн монгол, хятад уран зохиолыг харьцуулсан тухай сонгодог бүтээл болохуйц хоёр томоохон бүтээл хэвлүүлснээс гадна нэлээд олон тусгай сэдэвт цуврал өгүүлэл нийтлүүлж, хятад уран зохиолын монгол орчуулгын судлалаар дамжуулан монголчууд харь үндэстний утга зохиолыг орчуулан хүлээж авах явцад илэрсэн үндэстний гоо таашаал болон соёл сэтгэхүйн онцлогийг шинжлэн судалсан байна.

Монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо болон соёлын харилцааны судлал нь Инжинаш судлалд нэлээд төвлөрч, Намжилцэвээн, Ц. Хишигтогтох, Рэнцэндорж зэрэг эрдэмтэд олон арван өгүүлэл нийтлүүлсэн байна. Чин улсын үеийн монгол, хятад үлгэрийг харьцуулсан судалгаанд Т.Цэрэнсодном, Б.Ринчин, Жалга, Чэнь Ганлун (陈岗龙-chen gang long), Жиньрун (金荣-jin gong), Бай Үйрун (白玉荣-bai yu rong), Уеэ (伍月-wu yue) зэрэг эрдэмтэд нэлээд дорвитой судалгаа хийсэн байна.

Нэг. Юань, Мин улсын үеийн монгол, хятад уран зохиолын харьцуулалт, онцлог

Монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо бол монгол, хятад үндэстний урт хугацааны улс төр, аж ахуй, соёлын харилцааны сууринд сая бий болж хөгжиж ирсэн юм. Чингис хаан 1206 онд Их Монгол улсыг байгуулснаас хойш, монгол үндэстэн хятадын соёлтой ойртон харилцаж эхэлжээ. Иймдээ монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо нь Юань, Мин, Чин гурван түүхэн цаг үетэй холбогдоно. Доор Юань, Мингийн үе болон Чингийн үе гэх хоёр үед хувааж товч өгүүлье.

Юань улсын үеийн онцлог. 1260 онд Хубилай Их Монгол улсын хаан сууринд сууж улсын цолыг “Юань” хэмээн өргөмжилснөөс хойш “Монгол” гэдэг нэр нь үндэстний нэр болсон байна. Хубилай хаан Юань улсыг байгуулсны дараа бүх улсыг нэгтгэж, монгол үндэстний байр суурьд томоохон хувиралт гарч, монголчуудын нүүдлийн мал аж ахуйн соёл нь Дундад орны тариалах соёлтой харилцаа үүсэж, соёлын хоорондох харилцаа ба солилцоо идэвхжиж монгол, хятад соёлын харилцаа нь анх удаа идэвхтэй явагдаж, монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо нь улам эрчимтэй хөгжсөн байна.

Юань улсын үе дахь монгол, хятад уран зохиолын хоорондох солилцоо ба нөлөөлсөн байдлыг ерөнхийлөн үзвэл, дараах хэдэн зүйлээр илэрч байна. Үүнд: Нэгдүгээрт. Монгол үндэстний уламжлалт соёл, ёс заншил, дуу бүжиг, хөгжим зэрэг нь Юань улсын үеийн ший жүжиг, шүлэг дууллын зохиол бүтээлд үзүүлсэн нөлөө; Хоёрдугаарт. Монгол үндэстний эрдэмтэн мэргэд хятад хэлээр зохиол бүтээлээ туурвисан; Гуравдугаарт. Хятад үндэстний бичгийн хүмүүс монгол үндэстний амьдралыг харуулан тусгасан уран зохиолыг туурвисан явдал болно (Yunfeng, 1997, p. 1). Энэ үеийн онцлогийг дараах хэдэн зүйлээр тодорхойлж болно. Үүнд:

1. *Монгол үндэстнээс Юань улсын үеийн ший жүжиг, шүлэг дууллын зохиол бүтээлд үзүүлсэн нөлөө.* Юань улсын үеийн ший жүжиг (杂剧) болон дуурь (散曲)-г хамтад нь “Юань улсын үеийн дуулалт жүжиг” гэж, Юань улсын үеийн уран зохиолын хөгжлийн оргилыг тодорхойлж байдаг. Энэхүү амжилт нь түүний эл үндэстний соёлын харилцаа жич соёлын

нөлөөллөөс салж чадахгүй юм. Монгол болон бусад умардын цөөн тоот үндэстний дуу хөгжим, үг хэл үсэг бичиг нь их хэмжээгээр Дундад оронд орж ирэхийн зэрэгцээ Хятадын дуу хөгжим, ший жүжигтэй харилцан нөлөөлж, шинэ дуу хөгжим болон ший жүжгийн тогтолцоо бүрэлдэж, Юань улсын онцлог шинжийг тусгаад зогсохгүй олон түмний таашаалд нийцсэн байна. Гэхдээ түүхийн сурвалж бичгүүдийн мэдээ баримтуудыг үндэслэвэл, Юань улсын үед монгол зохиолч нар ший жүжгийн зохиол бүтээлийн туурвилд чухал байр суурийг эзэлж байжээ. Түүний дотор Ян Жинсян (杨景贤- yang jing xian) бол алдартай төлөөлөгч болно. Түүний зохиосон ший жүжгийн зохиолууд нь Юань улсын үеийн ший жүжгийн зохиол бүтээлийг бүрэн төлөөлдөг. Тэрээр 80 гаруй жүжгийн зохиол бичсэн бөгөөд түүний дотроос зөвхөн “Баруунш зорчсон тэмдэглэл” болон “Лиүшин шоу (刘行首- liu xing shou)” гэдэг хоёр дэвтэр жүжиг нь бүрэн бүтнээрээ бидний үед уламжлагдан ирсэн байна.

2. *Хятад хэлээр зохиол бүтээл туурвидаг монгол үндэстний зохиолчид.* Юань улсын үед хятад хэлээр шүлэг бичдэг монгол зохиолчид нэлээд олон байжээ. Энэ нь монгол, хятад уран зохиолын харьцаа холбооны нэгэн онцгой үзэгдэл гэж хэлж болно. Хятадаар зохиол туурвидаг нь хаан эзэн, сайд түшмэд, бичгийн хүмүүн ба бага тушаалтан, эгэл ард зэрэг олон давхаргын хүмүүсийг багтаана. Эдгээр зохиолчид зохиол бүтээлээ туурвих явцдаа монгол уран зохиолын уламжлал ба үндсэн хэв маягийг хадгалахаар зорьж байжээ. Юань улсын эхний үед, монгол зохиолчид сая хятад хэлээр зохиол бүтээл туурвиж байгаа учраас зохиолчдын тоо нь олон бус, ур чадвар, арга барил нь төдийлөн хөгжөөгүй байв. Гэвч тэдгээр нь говийн араас ирсэн бичиг, цэргийн түшмэл байсан учраас монгол үндэстний онцлог байдал, соёлын хэв шинж жич өөрийнхөө амьдралын тухай зохиол бүтээлдээ тусгаснаас, зохиосон бүтээлүүд нь агуулгын хувьд баян тансаг болж, тухайн үеийн хятад зохиолчдын бичсэн шүлэг дуулаас эрс ялгагдаж байв. Юань улсын эхний үе дахь хятад хэлээр зохиол бүтээлээ туурвидаг монгол зохиолчийн томоохон төлөөлөгч бол Баян (伯颜- bai yin) юм. Юань улсын дунд болон сүүлч үед, монгол үндэстний нэг хэсэг бичгийн хүмүүс хятад оронд удаан суурьшсаны зэрэгцээ хятад шүлэг зохиол ба ёс заншилд нэвтэрч, зохиол бүтээлийн илтгэх арга барил, үг үсэг, хэв маягийн тухайд хэтэрхий гоо сайхныг хөөцөлдөж, уран бүтээл дэх үндэстний онцлогийг хадгалах талаар Юань улсын эхний үеийн зохиол бүтээлээс жаахан суларсан боловч урлагийн илтгэх арга барилын талаар нэлээд боловсорч, хүмүүсийн анхаарлыг онцгой татаж байжээ. Садула (萨都刺- sa dou la), Тайбуха (泰不华 - tai bu hua), Елүбуха (月鲁不花 - yue lu bu hua), Ниэюн (聂铨 - nie yong), Майлю (买闾 - mai lu) зэрэг зохиолчид нэрд гарч байв. Үүнээс гадна хаан эзэн, тайж, гүнж зэрэг дээд давхаргынхан өөр өөрийн

өнцгөөс тухайн үеийн нийгмийн ахуй байдлыг тусгасан шүлэг зохиолыг туурвиж байжээ. Үүнд, Хубилай, Тугтөмөр, Тогоонтөмөр, Агай нар багтана.

3. *Монгол үндэстний амьдралыг тусган харуулсан хятад үндэстний зохиолчид.* Монгол үндэстний амьдралыг тусган харуулсан хятад үндэстний яруу найрагчдын шүлгийн бүтээл нь монгол орны байгалийн гайхамшигт өнгө үзэмж, хүн ардын зан заншил тэр дундаа хааны ордны ёслол, улс төрийн арга хэмжээ зэргийг агуулгад багтаан зураглаж, дүрслэхийг зорьж байв. Юань улсын нэр алдартай яруу найрагчид бүгд энэ талын агуулгыг тусгаж харуулсан шүлэг дууллыг бичиж байжээ. Жишээлбэл, Юанийн үеийн шүлгийн “дөрвөн дархан” гэж алдаршсан Үйжи (虞集-yu ji), Янзай (杨载 -yang zai), Фаньгуо (范梈- fan guo), Жиэ Сиси (揭傒斯-jie xi si) нар монгол амьдралыг бичиж байсан юм. Үүнээс гадна, Кэ Жиүси (柯九思 -ke jiu si), Ян Юньфү (杨允孚 -yang yun fu), Лиүгуань (柳贯- liu guan), Хужу (胡助 -hu zhu), Жоу Байчи (周伯琦-zhou bai qi), Жанүй (张昱 zhang yu), Ван Шиси (王士熙 wang shi xi), Хуанжинь (黄潛-huang jin), Гун Шитай (贡师泰 -gong shi tai), Чйү Чүжи (邱处机 -qiu chu ji), Лиү Бинжун (刘秉忠 -liu bing zhong), Хаожин (郝经 -hao jing), Юаньжүэ (袁桷 -yuan jue), Сү Юүрэн (许有壬 -xu you ren) нар байдаг. Эдгээр хүмүүсийн олонх нь төрд хүчин зүтгэж байсан учраас зохиол бүтээлүүд нь голдуу ордны дуулал ба дээд нийслэлд жуулчилсан аяллын шүлэг дээр төвлөрсөн байдаг.

Мин улсын үеийн онцлог. Мин улсын үед, монголчууд Дундад орноос ухран гарч, Умард Юань улсыг байгуулан цагаан хэрмээс хойших нутаг дэвсгэрийг ноёрхож байв. Мин улс нь монголчуудыг бүрэн эрхшээлдээ оруулахаар урд хугацаанд дайтаж, Монголын дотоодын хагацал ба дайн дажны сүйдлээс болж монгол соёл, уран зохиолын хөгжил бууралтын шатанд орж, монгол, хятад уран зохиолын харьцаа холбоонд ихээхэн нөлөөлжээ. Монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо төдийгүй монгол үндэстний өөрийн уран зохиолын хөгжилтөд ч нөлөөлсөн байна. Жишээлбэл, XVI зууны эцэс хүртэл монголоор бичсэн түүхэн зохиол бараг үлдэж уламжлагдсангүй. Харин XVII зууны үед “Алтан товч” зэрэг зарим нэг түүхэн зохиол зохиогдсон байна. Гэсэн ч цохон тэмдэглүүштэй нь, бидний үед уламжлагдан ирсэн “Монголын нууц товчоо” нь XIV зууны сүүл үеийн бар хэвлэл юм. Мин улсын Тайзү хааны үед “Монголын нууц товчоо”-г монгол үсгийн эхийг хятад үсгээр авиалан галиглаж, үг бүрийн хажууд хятад орчуулга хадаад, хэсэг бүрийн товч агуулгыг утгачлан хятадчилсан байна. “Монголын нууц товчоо”-ны энэхүү эхийг Мин улсын үед “Юаний нууц товчоо” гэж нэрлэж байжээ. Энэ тухай “Мин улсын үнэн тэмдэглэл”-гийн 141-р боть дахь “Тайзү хааны үнэн тэмдэглэл”-д “Хун у-гийн 15-р оны цагаан сарын улаан нохой өдөр бичгийн мэргэдийн хүрээлэнгийн Хуо

Юаньжи (火源洁) нарыг зарлигдаж Хуа-и и-үй (华夷译语)-г найруулахдаа “Юаний нууц товчоо”-г дахиж авчран хяналт хийж, үсгийг нь холбож авиаг нь зохицуулсугай” хэмээн тэмдэглэв. Энэ бол “товчоо”-ны тухай түүх судар дахь анхны тэмдэглэл болох бөгөөд Мин улсын үед “Юаний нууц товчоо” гэж нэрлэж байсны гэрч баримт болно (Жалпунга, М. Мөнх, Б, 2017, х. 253). Хэдийгээр уулын уйгуржин үсгийн эх нь бидний үед уламжлагдан ирсэнгүй боловч “Монголын нууц товчоо”-ны хятад галигийн эхээр арван хоёр боть болон арван таван боть нь адил бус эхээр бидний үед уламжлагдсаар иржээ.

Хоёр. Чин улсын үеийн монгол, хятад уран зохиолын харьцуулалт, онцлог

Чин улсын үед монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо нь урьд үеэс эрс хөгжсөн цаг үе байжээ. Энэ тухай Жалга (扎拉嘎 zha la ga) бичихдээ “Дундад улсын эл үндэстний утга зохиол нь харьцаа холбоо болон харилцан дэвшлийн дунд хөгжиж ирсэн юм. Дундад улсын эл үндэстний утга зохиолын харьцаа холбооны дунд, Чин улсын үеийн монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо нь зохих нийтлэг утга агуулгатай билээ. Чингийн үеийн монгол, хятад уран зохиолын харьцаа холбоонд багтах уран зохиолын үзэгдэл нь цар хүрээгээр өргөн, хамрагдах бүтээлийн тоо нийлээд олон бий” (Jalga, 2002, p. 1) хэмээн дүгнэсэн байдаг. Эдгээр бүтээлүүдийг төрөлжүүлэн хувааж үзвэл дараах дөрвөн төрөл болно. Үүнд:

Нэг. Хятадын бүтээлүүдийг монгол хэлэнд орчуулсан байдал. Чингийн үеийн монгол, хятад уран зохиолын харьцаа холбооны хөгжилт нь хятад уран бүтээлийг монголчлох ажлаар эхэлж бөгөөд тэр дундаа хятад туужийг монгол хэлэнд орчуулах ажил нэн чухал байв. XVII-XIX дүгээр зууны хугацаанд монголчуудын орчуулгын бүтээлийн оргил үе болж хятад хэлнээс зуу гаруй ном зохиолыг орчуулсан байна. Одоогоор олдож бий материалыг үндэслэвэл, 1721 онд “Баруунш зорчсон тэмдэглэл”-ийг товчлон орчуулсан “Тансан ламын үлгэр” нь хамгийн эрт орчуулсан бүтээл гэж үзэж болно. Чингийн үеийн хятад уран бүтээлийг монголчлох ажиллагаа нь их төлөв XVII дугаар зууны эхний үеэс XVIII зууны дундаж үе, XVIII дугаар зууны дундаж үеэс XIX дүгээр зууны эхний үе болон XIX дүгээр зууны эхний үеэс XX дугаар зууны эхний үе гэх гурван шат үе хувааж болно. Нэгдүгээр шатан дахь хятад уран бүтээлийг монголчлох ажиллагаа нь голдуу Чингийн засгийн дэмжлэгээр болон шууд эрхлэлтээр явагдаж байжээ. Орчуулгын ажилд оролцож байсан хүмүүс нь гол төлөв Чингийн төрд өргөмжлөгдсөн ноёд буюу төрийн албанаас элссэн бичгийн түшмэд байжээ. Тэд гол төлөв Күнзийн сургаалын сонгодог зохиолыг орчуулж байв. Үүний дагуу нийлээд олон хятад зохиолын монгол орчуулгын бүтээл нь манж хэлний орчуулгаас орчуулсан байдаг. Энэ нь тухайн үеийн Чингийн засгийн газраас монголчуудад явуулж байсан төрийн бодлоготой нягт холбоотой юм. Энэ хугацаанд орчуулсан бүтээлд “Их Ляо улсын түүх”, “Алтан улсын түүх”, “Их

Юаний түүх”, “Шүлэглэлт ном”, “Баруунш зорчсон тэмдэглэл” болно. Хоёрдугаар шатыг хятад зохиол бүтээлийг монголчлох ажлын зогсонги үе шат гэж хэлж болно. Энэ үед монголын найман хошуунд хятад хэлийг сурч хэрэглэх болсноор, хятад уран бүтээлийг монголчлох ажиллагаа нь өөрийн үнэ өртгөө алдаж, орчуулгын бүтээлүүд ховордсон байна. Гуравдугаар шатанд хятад уран бүтээлийг монголчлох ажиллагаа нь шинэ цаг үед орсон байна. Даруй Чингийн дунд болон сүүл үеэр тухайлбал, хар тамхины дайны өмнө болон дараа гадаадын дайн ба дотоодын нийгэм түүхийн өөрчлөлтөөс болж Манж Чингийн үндэстний харилцааг түгжиж байсан төрийн бодлого нь аажмаар суларч, их хэмжээний хятад хүмүүс монгол оронд нүүн ирж хятад соёлыг Монгол оронд авчирснаар монгол орчуулга үүнийг дагалдан ихээр хөгжсөн байна. Бүх улсын монгол эртний хуучин номын материалын хамтарсан гарчиг (全国蒙文古旧图书资料联合目录) болон “Дундад улсын монгол хэлний эртний номын ерөнхий гарчиг (中国蒙古文古籍总目)”-аас үзвэл Хятадын үлгэр зохиолын монгол орчуулгын бүтээлүүд нь нийт 44 байна (Jalga, 2002, х. 44).

Оросын монгол сурвалж бичиг судлаач эрдэмтэн А.Сатжин (阿·萨特金) Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Дорно дахин судлалын тасгаас нэгэн гарчиггүй монгол орчуулгыг олжээ. Тэр нь Хятадын 34 бүтээлийг орчуулан оруулжээ. Нэргүй номын гарчигт “Олон улсын бичиг (列国志)”, “Жүн дагинын үлгэр (钟无盐)”, “Баруун Хань улсын бичиг (西汉演义)”, “Зүүн Хань улсын бичиг (东汉演义)”, “Гурван улсын үлгэр”, “Си ма мао зарга таслах үлгэр (司马貌断案故事)”, “Сүй, Тангийн үлгэр (隋唐演义)”, “Их Тан улс Баруун Лян улсыг төвшитгөсөн судар (大唐定西凉传)”, “Инлиэ жуань (英烈传-ying lie zhuan)”, “Алтан лянхуа (金瓶梅-jinping mei)”, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”, “Жидянь хуушааны үлгэр (济颠和尚的故事)”, “Шүйхү шастир (水浒传)”, “Ши гүнгийн хэрэг (施公案)” зэрэг маш олон тооны монгол орчуулгын хуулмал нь адагтаа 1864 оноос өмнө байсан, түүний доторх 20 гаруй бүтээлүүд нь Чингийн дунд үеэр орчуулсан байна (Оууна, 2009.х.3). Үүнээс үзвэл, Хятадын уран бүтээлүүдийг монгол хэлэнд олноор нь орчуулснаар Чин улсын монгол, хятад уран зохиолын харьцаа холбоо болон соёлын харилцааны түүхэнд ач холбогдолтой байжээ. Тэр нь монгол үндэстэн хийгээд Дундад орны соёлын солилцоог хөгжүүлснээр үл барам монгол утга зохиолын сэргэлт болон хэлбэрийн шилжилтийг хөгжүүлсэн төдийгүй, ойр үеийн ардчилсан үзэл санаа Монгол оронд дэлгэрэхэд ихээхэн нөлөөлжээ. Хасбугаас Инжиннаш хүртэл, тэд нарын монгол уран зохиолыг дахин сэргээн хөгжүүлэх явцад ч гэсэн хятад уран зохиолыг монгол хэлээр орчуулах ажлаас салж чадаагүй юм.

Хоёр. Хятад уран зохиолын нөлөө хүртсэн монгол уран зохиол. Энэ нь дараах хэдэн онцлогтой. Үүнд:

1. Хятадын туужийн орчуулгыг дуурайн, Дундад орны түүх ба үлгэр шастираас сэдэвлэн зохиосон монгол үлгэрийн бэнсийн шинэ туурвил бий болсон байна.

Монгол үндэстний зохиосон эдгээр үлгэрийн бэнсийн шинэ туурвил нь Хятадын туужийн уран бүтээлгийн арга болон урлагийн арга барилыг сурч хэрэглэж, Хятадын туужийн үлгэр үйл явдлыг шингээж, монгол бичгийн хүмүүсийн сэтгэхүйгээр Дундад орны үлгэрийг төсөөлөн зурагладаг. Бэнсийн үлгэр хийгээд үлгэрийн бэнсийн шинэ туурвил бол Хятадын үлгэр шастирын монгол орчуулгын ажиллагааны өрнөлтийн дараа монгол уран зохиолын хөгжилтийн нэгэн шинэ үзэгдэл болно. Энэ тухай Жалга (扎拉嘎 zha la ga) бичихдээ “Бэнс үлгэр бол уран сайханчдын амаар хэлж дуулах үлгэр мөн, ардын аман зохиолын айд харьяалагдана. Үлгэрийн бэнс бол цаасан дээр бичиж тэмдэглэсэн үлгэр, бичгийн уран зохиол доторх роман, туужийн айд харьяалагдана” (Su Herong, Yong Xianzhao, Yi Ruliang, Jalga, 2000, p. 187) гэж дурдсан байна. Бэнс үлгэр болон үлгэрийн бэнс шинээр зохион бичих ажил бол Чингийн үеийн монгол, хятад уран зохиолын харьцаа холбоон дундах хамаа бүхий хоёр томоохон явдал болох бөгөөд монгол уран зохиол болон үндэстний соёлын уламжлалын суурин дээр Хятадын уран зохиолын өвийг идэвхтэй хүлээн авах хийгээд хятад соёлын нөлөөний харилцан үйлдлийн дүнд хөгжиж ирсэн юм. Чингийн үеийн монгол, хятад уран зохиолын харьцаа холбооны түүхэнд “Таван шастир” нь чухал байрыг эзэлдэг. Энэхүү таван шастир нь “Күси жуань (苦喜传- ku xi zhuan)”, “Чуаньжи фү (全家福- quan jia fu)”, “Шаняо жуань (殇妖传-shang yao zhuan)”, “Чипи жуань (契僻传- qi pi zhuan)”, “Чянху жуань (羌胡传- qiang hu zhuan)” болно.

2. Монгол үндэстний бодит амьдрал болон түүхээр сэдэвлэсэн роман мэндэлсэн байна. Энэ тухай Инжинаашийн зохиосон роман нь чухал байрыг эзэлж байдаг. Инжинааш хятад хэлний роман туурвих арга туршлагыг идэвхтэй суралцаж, “Улаан үүлний нулимс”, “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйхлах танхим”, “Хөх судар” зэрэг монгол үндэстний бодит амьдрал буюу монгол үндэстний түүхээр сэдэвлэсэн нэг бүлэг романуудыг туурвин бүтээж, монгол романы шинэ цаг үеийг эхлүүлэн, монгол уран зохиолын түүхэнд цоо шинэ дэг хэлбэрийг бий болгосноор үл барам монгол утга зохиолын туужийн зохиолын бүрэлдлийг бүрдүүлжээ. Инжинааш ингэж өөрийнхөө зохиол туурвилаараа дотор газрын давшингүй үзэл санаа болон уран зохиолын гол үзэлтийг монгол оронд дэлгэрүүлэн, монгол хятад уран зохиол ялангуяа соёлын харилцааг эрчимтэй хөгжүүлжээ. Инжинааш бол монгол үндэстний агуу их утга зохиолч болохоор үл барам монгол хятад уран зохиолын агуу их хөгжүүлэгч мөн.
3. Монгол үндэстний туужийн онол, шүүмжлэлт хандлага хөгжсөн байна. Туужийн шүүмжлэлийн төлөөлөгч зохиолч бол Хасбу болно. Хасбугаас “Эрт эдүгээгийн гайхамшигт үзэгдэл” болон “Улаан асрын зүүд”-ийг орчуулж, “Тан гүн и ши” болон “Тан гүн и ши-гийн нөхвөр”-ийг найруулж орчуулан, Жинь Шэнтан (金圣叹- jin sheng tan), Жан Жүпо (张竹坡-zhang zhu po), Жан Синьжи (张新之- zhang xin zhi), Ван Силян (王希廉-wang xi lian) зэрэг

хүмүүсийн туужийн шүүмжлэлийн аргыг уламжлан сурч Хятадын эртний алдарт роман “Улаан асрын зүүд”-ийг шүүмжлэн өгүүлсэн нь монгол үндэстэн төдийгүй хятад үндэстний дотор маш чухал байрыг эзэлж байдаг юм. Түүний шүүмж өгүүлэлд хамрагдаж яригдсан зүйл олон бөгөөд багцлаад хэлбэл гол төлөв “Улаан асрын зүүд”-ийн тухай шүүмж, утга урлагийн тухай өгүүлэл болон үг, үсэг хэрэг явдлын зүүлт тайлбар зэрэг болно.

4. Монгол хэмжээт шүлгийн зохиолчид бий болсон байна. Хятадын хэмжээт шүлгийн нөлөөн дор, Ванчинбал, Гүүлранз, Хөгнөчөө, Сүнвайтанзун, Инжинааш нар Хятадын хэмжээт шүлгийн шүлэглэх арга, хэв маяг болон илтгэх арга барилыг уламжлан авч монгол шүлгийн уламжлалт шүлэглэх арга, хэв маяг, илтгэх арга барилтай уялдуулан монгол шүлгийн шинэ хэлбэр, шинэ дэг маягийг тогтоож, монгол шүлгийн тогтолцоог бүрэлдүүлсэн байна.

Гурав. Хятад хэлээр зохиол бүтээлээ туурвидаг монгол үндэстний зохиолчид. Юань улсын үеэс эхлэн монголчууд хятад хэлээр зохиол бүтээлээ бичдэг уламжлалтай билээ. Чингийн үе болоход хятадаар зохиол бичдэг монгол үндэстний зохиолчид зуу гаруйгаар тоологдож, цаашид зохиолчийн эгнээгээ тэлсээр байжээ. Зохиолчийн эгнээд хаад, ноёд, ван, гүнгүүд зохиол бүтээл туурвидаг байснаа улам хүрээгээ тэлж энгийн ардууд болон бичгийн хүмүүс зохиол бүтээл олноор туурвих болсноор монгол хятад уран зохиолын харьцаа холбоо өргөжин тэлсэн байна. Үүнд төлөөлөгч чанартай монгол үндэстний зохиолч гэвэл Мэнлин (梦麟-meng lin), Бомин (博明-bo ming), Хэ-инь (和瑛-he ying), Сунжунь (松筠-song jun), Байсүй (柏葭-bai sui), Фа Шишин (法式善-fa shi shan), Үйчянь (裕谦-yu qian), Рүйчан (瑞常- rui chang), Насанламба (那逊兰保-na xun lan bao), Ворэнь (倭仁-wo ren) зэрэг болно. Эдгээрийн олонх нь эрт үеэс эхлэн хятад оронд хэдэн үеэрээ нутагшин сууж, Хятад соёл, боловсролыг сурч эзэмшсэн учир тэдний туурвисан зохиол бүтээлүүд нь хятад зохиолчийн зохиол бүтээлтэй нийлээд төстэй байдаг.

Дүгнэлт

Монгол, хятад уран зохиолыг харьцуулан судалсан судалгааны ажил нэлээдгүй хийгдсэн боловч онолын болон судалгааны арга барилын хувьд нарийвчлан судалж, тодруулах шаардлагатай асуудлууд оршсоор байна. Ийм учраас дараах хэдэн санал, дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол, хятад уран зохиолыг харьцуулан судлах онолыг улам боловсронгуй болгох шаардлагатай байна. Монгол, хятад уран зохиолын түүхийг тогтолцоотой, бүрэн эзэмшээний үндсэн дээр монгол, хятад уран зохиолыг харьцуулан судлах онолыг тодорхойлон хөгжүүлэх боломжтой юм.
2. Монгол, хятад уран зохиолыг харьцуулан судлахад монгол, хятад хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй. Монгол, хятад уран зохиолыг харьцуулсан судлал нь заавал хоёроос дээш үндэстний хэлийг сайтар эзэмшсэн байхыг шаардана. Ялангуяа, монгол, хятад уран зохиолыг

харьцуулан судлахад эртний хятад хэлийг сайтар эзэмшсэн байх нь судалгааны үр дүнд шууд нөлөөлнө.

3. Монгол, хятад уран зохиолыг харьцуулан судлахад харьцуулсан утга зохиолын аргаар судлах нь нэн тохиромжтой. Харьцуулсан утга зохиолын онол, үзэл хандлагаар монгол, хятад уран зохиолын харилцааг шинжлэн үзэж, харьцуулалтын үр дүнгээс монгол уран зохиолын үндэстний онцлогийг тодруулан гаргаж, монгол уран зохиолын судалгааг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэх боломжтой юм.

Ном зүй

- Jalga. (1984). A study of Nigen Dabhur Asar ,Ulagana Ohilahu Tinghim and Hong Lou Meng. . Huh hot: Inner Mongolia People`s Publishing House.
- Jalga. (2002). Comparative Literature: A comparative study of the parallel nature of literature— On the relationship between Mongolian and Chinese literature in Qing Dynasty. Huh hot: Inner Mongolia Education Press.
- Oyuna. (2009.03). On the versions of Mongolian translation of Chinese Novels in Qing Dynasty. Studies of Ethnic Literature.
- Su Herong., Yong Xianzhao., Yi Ruliang., Jalga. (2000). History of Mongolian literature (Volume 3). Huh hot: Inner Mongolia People`s Publishing House.
- Tsolmontsetseg. (2005.02). On the background of poetry creation in Yuan Dynasty. Journal of Chifeng University.
- Tumurbagana, B. (1999.06). On the social and historical background of Ancient Mongolian Writers' Chinese writing. Journal of Inner Mongolia Normal University.
- Tumurbagana, B. (2002). A textual research on Chinese writing of Ancient Mongolian Writers. Huh hot: Inner Mongolia Education Press.
- Yunfeng. (1992). On the cultural exchange between Mongolian and Chinese by the Side view The history of Mongolian writing in Chinese. Tianjin: Ancient Books Publisging Hous.
- Yunfeng. (1997). The history of Mongolian Chinese literature relations. Xinjiang: People`s Publishing House.
- Yunfeng. (2003.04). On the Influence of the Mongolian Nationality and its Culture on the Rise and Fall of the Yuan Drama. . Huh hot: Philosophy and Social Science.
- Yunfeng. (2004). On the influence and contribution of Mongolian nationality and its culture to the creation of Yuan Sanqu. Beijing: Nationalities Publishing House.
- Yunfeng. (2004.02). On the influence and contribution of Mongolian nationality and its culture to the creation of Yuan Sanqu. Studies of Ethnic Literature.
- Yunfeng. (2004.04). Mongolian Chinese writing in Qing Dynasty and its influence on Confucianism. Journal of the Central University for Nationalities.

- Yunfeng. (2005). On the relationship between Mongolian and Chinese literature in Yuan Dynasty. Beijing: Nationalities Publishing House.
- Жалпунга, М. Мөнх, Б. (2017). Монгол үндэстний уран зохиолын нэвтэрхий түүх. Хөх хот: Өвөр Монголын Сурган Хүмүүжүүлэх Хэвлэлийн Хороо.
- Чюси. (2002). Юань улсын үеийн монгол шүлэгчдийн хятад шүлэг дахь домогт өгүүлэмж. Монгол хэл, утга зохиол.

Comparative Study of the Mongolian and Chinese Literatures during Yuan, Ming, and Qing Dynasties

Sod

School of Mongolian Studies Inner Mongolia University, official at the headquarters of the People's Republic of China department of immigration, China

Corresponding author: taivansuren@yahoo.com 

Received: 7/04/2020/

Revised: 8/25/2020

Accepted: 9/25/2020

Abstract

The study of the Mongolian and Chinese literary relationships is mainly focused on the study of literary works written during the Yuan Dynasty, Ming Dynasty, and Qing Dynasty. A number of scholars and researchers put their work on this study, including key scholars such as Yunfeng, Tumurbagana.B, Jalga Chusi, Tsolmontsetseg, Namjiltseven, Khishigtogtokh.Ts, Rentsendorj, Tserensodnom.T, Rinchen.B, Chen Ganlong, Jinrong, Bai Uirong, and Uye.

After the foundation of the Yuan Dynasty, Kublai Khan united all the Mongolian kingdoms. The national position of the Mongols emerged with a significant transition resulting from the cultural interrelations between the Mongolian nomadic animal husbandry and the Chinese agriculture. The increasing interconnections and interchanges between the two cultures led to the initial stage of the development in the relationship between the Mongolian and Chinese literatures. Later, during the period of Ming Dynasty, due to the protracted wars between the Mongolian and Ming peoples, the Mongolian literature suffered a slow-down which also affected the Mongolian-Chinese literary relationship. During the Qing dynasty, however, the Mongolian-Chinese literary relationship experienced a rapid outburst significantly advancing the development of the Mongolian literature.

In conclusion, I intended to briefly overview the study of the Mongolian-Chinese literary relationships during the Yuan Dynasty, Ming Dynasty, and Qing Dynasty, and express my opinion and conclusion on the Mongolian-Chinese literary relationship concurrently.

Keywords

Mongolian-Chinese literary relationships during the Yuan dynasty, Ming dynasty, and Qing dynasty, communication, coordination